

## “Булл капитал ББСБ” ХХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан

“Булл Капитал ББСБ” ХХК-ийн 2022 оны Үйл ажиллагааны нэгдсэн тайланг хүргэж байна.

Манай Компанийн хувьд тухайн жилд Бизнес төлөвлөгөөний дагуу тавьсан зорилго, зорилтуудаа бүрэн ханган ажилласныг мэдээлэхэд таатай байна.

Бид уламжлалт зээл буюу Бизнесийн зээл, бизнесийн зээлийн шугам, автомашины зээл болон хэрэглээний зээлийн бүтээгдэхүүн болон Итгэлцлийн үйлчилгээг зах зээлд санал болгон ажиллаж байна.

№	Үндсэн ажиллагааны хүрээнд:
1	2022 оны I болон II улиралд дүрмийн санг тус бүр 3.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 7.4 тэрбум төгрөгт хүргэсэн.
2	СЗХ болон ҮЦАЭХ-ны зөвшөөрлийн дагуу Биржийн бус зах зээл дээр 2022 оны 07-р сарын 29-ний өдөр жилийн 18.0 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай, бүрэн даатгагдсан хаалттай бондыг “Стандарт инвестмент ҮЦК” ХХК, “Номин даатгал” ХХК “Кэй И партнерс” ХНХ-уудтай хамтран гаргасан.
3	ICT группийн охин компани болох “Интелижиент финанс” ХХК-тай хамтран “I Finance” үндсэн бүртгэлийн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.
4	СЗХ-оос шинэчлэгдэн батлагдсан Компанийн засаглалын кодексын дагуу шаардлагатай бүх бодлого, журмуудыг боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн. 2022 оны эцэст Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээгээр нийт ББСБ-ын хэмжээнд 3 дугаарт эрэмбэлэгдсэн.
5	Зөв засаглалын зарчмын дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж, үйл ажиллагааг идэвхжүүлсэн.
6	Төв, Чингэлтэй, Хан-Уул, Сентрал тауэр, Уранган, Авто цогцолбор салбаруудын зөвшөөрлийг СЗХ-оос авч үйл ажиллагааг эхлүүлснээр нийт 6 салбартай болсон.
7	Компанийн эрхэм зорилго, Үнэт зүйлс, Брэндбүүкийг зорилго, зорилтуудтайгаа уялдуулан шинэчилсэн.
8	Хаан банкны Корпрэйт гэтвэй үйлчилгээнд бүрэн холбогдсон.
9	Компанийн <a href="http://www.bullcapital.mn">www.bullcapital.mn</a> вэбсайт болон <a href="http://bullcapital.nbf">bullcapital.nbf</a> пэйж хуудсыг нэвтрүүлсэн.
10	Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай бүх бодлого, дүрэм, журмуудыг бүрэн боловсруулж, мөрдөж эхэлсэн.
11	Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөг баталж, дараах чиглэсэн сургалтуудыг тогтмол явуулсан. Үүнд: <ol style="list-style-type: none"> <li>1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх тухай сургалт;</li> <li>2. Кибер аюулгүй байдлын тухай сургалт;</li> <li>3. Мэдээллийн аюулгүй байдлын тухай сургалт;</li> <li>4. Бизнесийн процесс, харилцагчийн үйлчилгээний сургалт;</li> <li>5. Бусад</li> </ol>



12	СЗХ-оос Итгэлцэл, Факторингийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг нэмж авсан.
13	Ажилтнуудын бодит гүйцэтгэлд суурилсан гүйцэтгэлийн үнэлгээг нэвтрүүлсэн.
14	<p>Компанийн ТУЗ-өөр дараах асуудлуудаар 80-100% ирцтэйгээр хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гарган ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>✓ Гүйцэтгэх захирлын томилгоотой холбоотой асуудлаар 1 удаа,</li><li>✓ ТУЗ-н гишүүдийн томилгоотой холбоотой асуудлаар 2 удаа,</li><li>✓ Холбогдох бодлого, заавар, журмууд батлах чиглэлээр 15 удаа,</li><li>✓ Бизнес төлөвлөгөө, төсөв, төлөвлөгөө батлах чиглэлээр 3 удаа</li><li>✓ Салбар нэгж байгуулах чиглэлээр 5 удаа,</li><li>✓ Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй байгуулсан хэлцлийн асуудлаар 5 удаа,</li><li>✓ Санхүүгийн байгууллагаас санхүүжилт авахтай холбоотой асуудлаар 5 удаа,</li><li>✓ Бусад асуудлаар 3 удаа тус тус нийт 24 удаа хуралдсан байна.</li></ul>
<b>Эрсдэлийн удирдлага:</b>	
15	<ul style="list-style-type: none"><li>✓ Эдийн засаг, зах зээлийн нөхцөл байдал, Төрийн зохицуулагч байгууллагуудын шийдвэр, чиглэлийг анхааралтай ажиглаж, шаардлагатай арга хэмжээг шуурхай авч ажилласан.</li><li>✓ Зээл, Итгэлцэл, Факторинг, Санхүү, Комплаинс, Үйл ажиллагааны эрсдэл тэдгээртэй холбоотой процессыг үнэлж, сайжруулсан.</li><li>✓ Дээрх эрсдэлүүдийн үнэлгээний тайлангийн асуудлаар 2 удаа, зээлийн эрсдэлийн чиглэлээр 2 удаа, нийт 4 удаа ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хорооны хурал 100 хувийн ирцтэй хуралдсан.</li><li>✓ ТУЗ-ийн дарга, гишүүдийг томилж, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулсан.</li><li>✓ ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүнийг томилсон ба аудитын нэгжийн төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд шууд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангадаг. Аудитын нэгж нь төлөвлөгөөний дагуу бүх нэгжид нэг удаа аудит хийсэн.</li><li>✓ Санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор давхар болон дараалсан хяналтын систем нэвтрүүлж, мөнгөн урсгал төлөвлөлтийг тогтмол хийн хөрвөх чадварыг ханган ажилласан.</li><li>✓ Санхүүгийн байгууллагууд болон итгэлцэл байршуулсан харилцагчдын өмнө хүлээсэн үүргээ цаг тухайд нь бүрэн биелүүлж ажилласан.</li><li>✓ Санхүүгийн Зохицуулах хорооноос мөрдүүлдэг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа”-ны тоон болон чанарын шаардлагыг хангасан.</li><li>✓ Мэдээллийн аюулгүй байдлын хэвийн үйл ажиллагааг хангах, нууцлалыг хамгаалах, мэдээллийн системийн хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор тогтмол хяналт тавьж, сайжруулалт хийн ажилласан байна.</li><li>✓ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Үйл ажиллагаанд мөрдөгдөж буй гэрээ, үйлчилгээний нөхцөлүүдэд хуулийн хянан нийцүүлэлт хийж, дүгнэлт гарган тэдгээрт шинэчлэлт оруулсан.</li></ul>



	<ul style="list-style-type: none"><li>✓ Компанийн дотоод эрсдэлийн бодлого, журмын хэрэгжилтийн үнэлгээг хийсэн бөгөөд тус үнэлгээний дүгнэлтийн дагуу сайжруулалт хийх төлөвлөгөөг гаргасан.</li><li>✓ Компани нь “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх дотоод хяналтын хөтөлбөр”-ийг шинэчлэн баталж, дотоод системийн түвшинд сэжигтэй үйл ажиллагааг илрүүлэх ажиллагааг нэвтрүүлэн ажилласан.</li></ul>
	<b>Хамтын ажиллагаа:</b>
16	<p>“Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам”-ын дагуу хөрөнгө оруулагч, бусад оролцогч талуудтай хамтран ажиллахдаа харилцан ашигтай байх, тэдгээрт тогтсон цаг хугацаанд үнэн зөв, тодорхой, ойлгомжтой, хүртээмжтэй байх зарчмыг баримталсан. Мөн компанийн болон хөрөнгө оруулагч, бусад оролцогч талуудын эрх ашиг, нээлттэй байх зарчмын зохистой тэнцвэрийг ханган ажилласан.</p> <p>Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, стратеги түүний хэрэгжилтийн мэдээлэл, бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдал, Гүйцэтгэх удирдлага болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрүүдийн талаарх мэдээлэл болон бусад шаардлагатай мэдээллүүдийг Хөрөнгө оруулагч, бусад оролцогч нарт <a href="http://www.bullcapital.mn">www.bullcapital.mn</a> цахим хуудас, биечилсэн уулзалт, <a href="mailto:info@bullcapital.mn">info@bullcapital.mn</a> цахим шуудан, 77303377 лавлах утасны дугаар, холбоо харилцааны бусад хэрэгслүүдийг ашиглан тогтмол нээлттэй мэдээллэж, санал хүсэлт, гомдлыг мөн нээлттэй хүлээн авч шийдвэрлэх, сайжруулах тасралтгүй систем ажиллаж байна.</p> <p>Мөн хөрөнгө оруулагч, бусад оролцогч нарт түргэн шуурхай, мэргэжлийн, хариуцлагатай байх, хэрэгцээ шаардлагад нийцсэн байх тал дээр анхаарч ажиллалаа.</p>
17	<p>Зээлийн борлуулалтын голлох хувийг эзэлж буй Автомашин барьцаалсан зээлийн хувьд тээврийн хэрэгсэл болон жолоочийн хариуцлагын даатгал дээр дотоодын “Практикал даатгал” ХХК, “Мандал даатгал” ХХК болон “Номин даатгал” ХХК-уудтай хамтран ажиллаж байна.</p>
18	<p>Ногоон бодлого боловсруулан мөрдөх, Ногоон бүтээгдэхүүнийг бий болгон зах зээлд нэвтрүүлэх болон Зээлдэгч, зээлийн бүтээгдэхүүний байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлэх, түүнийг бууруулах зорилгоор ТоС холбоонд элсэж, холбогдох заавар, зөвлөмжийг авч хэрэгжүүлж эхэлсэн. Компани нь 2023 оны 2-р улиралд багтаан байгаль орчныг хамгаалах бодлого, журмын хүрээнд сайжруулалт хийх төлөвлөгөөг гаргасан.</p>
19	<p>Үйл ажиллагаа өргөжин тэлж буйтай холбоотойгоор 6 Банк, санхүүгийн байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлсэн.</p>
20	<p>Автомашин хурдалдаа эрхлэгч 20 гаруй албан байгууллага, хувь хүмүүстэй хамтран ажиллаж байна.</p>
21	<p>“Мони маркет фанд” ХХК-тай “Репо” зээлийн төслөөр хамтран ажиллаж эхэлсэн.</p>
	<b>Нийгмийн хариуцлагын хүрээнд:</b>
22	<p>Компанийн Зээлийн бодлогод заасны дагуу Байгаль орчинд ээлтэй байх зарчмыг баримталж зээл хүсэгчийн эрхэлж буй бизнес, зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа нь нийгэм, бие хүн, байгаль орчинд хор нөлөөгүй байх шаардлагыг хангасан байх зарчмыг барьж ажилласан. Мөн автомашины нийлүүлэгч талуудын хамтын ажиллагааны хүрээнд Ногоон зээлийг олгож, тайланг зохицуулагч байгууллагад мэдээлэн ажиллаж байна.</p>
23	<p>Нийт ажилтнуудын эрүүл мэнд, цалин урамшууллыг сайжруулах зорилгоор холбогдох бодлого, журамд буцалтгүй тусламж, хөнгөлөлт урамшууллын системийг тусган, түүнийг хэрэгжүүлсэн.</p>

24	Компанийн цалингийн матрицыг шинэчлэн ажилтнуудын цалинг 30% хүртэл хэмжээгээр нэмэгдүүлж, үр дүнгийн урамшууллыг 2 удаа олгосон.
25	Эх үрсийн баярыг угтан ажилтнуудынхаа хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан зарлаж, идэвхжүүлэлт хийсэн.
26	Сонгинохайрхан уулын ойр орчимд ил задгай хаясан хог хаягдлыг түүж, ойр орчныг цэвэрлэн хуванцар хог хаягдалд ангилал хийн, зориулалтын хогийн цэгт буулгах аяныг Компанийн нийт хамт олны хэмжээнд зохион байгуулсан.
27	Ажилтнууд болон харилцагчдад зориулан нээлттэй номын санг бий болгосон.
28	Ажилтнууд болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд, хөдөлгөөнийг дэмжих зорилгоор долоо хоног бүр спортоор хичээллэж байна.
29	Нийт ажилтнуудын санаачилгаар “Ид шидийн орон хүүхэд хамгаалах хөгжлийн төв”-д дулаан хувцас, хичээлийн хэрэгсэл, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх сайн үйлсийн аяныг зохион байгуулсан байна.

### Эрсдэлийн бодлого:

Эдийн засаг, зах зээлийн нөхцөл байдал, төрийн зохицуулагч байгууллагуудын бодлого шийдвэрийг анхааралтай ажиглаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг түргэн шуурхай авч ажиллаж байна. Энэ хүрээнд дараах шийдвэрүүдийг гаргасан.

1. Төвлөрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд нэг харилцагчид тавих зээлийн хэмжээнд тодорхой хязгаарлалтууд тогтоосон.
2. Эдийн засгийн сектороор хязгаарласан зээлийн багцын хязгаарууд болон барьцаа хөрөнгийн үнэлгээний бодлогыг чангаруулсан.
3. Уул уурхай, барилгын салбар болон эдгээр салбаруудтай хамаарал бүхий орлогын эх үүсвэртэй харилцагчдад зээлийн хязгаарлалт тогтоосон.
4. Өр орлогын харьцааны шаардлагыг чангаруулсан.

### Санхүүгийн үзүүлэлт:

Бид Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган ажилласан. 2021 он болон 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлтүүд /сая.төг/	2021	2022	Өөрчлөлт
	Аудитлагдсан	Аудитлагдсан	2022 / 2021
<b>Санхүү байдлын тайлан</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	12.56	2,209.36	<b>17485%</b>
Цэвэр зээл	1,931.89	22,099.50	<b>1044%</b>
Хуримтлуулж тооцсон хүүний авлага	39.84	626.34	<b>1472%</b>
Бусад авлага	5.64	217.12	<b>3750%</b>
Бусад хөрөнгө	16.82	40.65	<b>242%</b>
Үндсэн хөрөнгө	20.85	173.63	<b>733%</b>
<b><u>Нийт хөрөнгийн дүн</u></b>	<b><u>2,027.61</u></b>	<b><u>25,366.60</u></b>	<b>1151%</b>
Итгэлцэл, өр төлбөр	604.80	16,314.42	<b>2597%</b>

Дүрмийн сан	1,400.00	7,400.00	<b>429%</b>
Хуримтлагдсан ашиг	22.81	1,652.17	<b>7143%</b>
<b>Нийт өр төлбөр, эзний өмчийн дүн</b>	<b><u>2,027.61</u></b>	<b><u>25,366.60</u></b>	<b>1151%</b>
<b>Орлого үр дүнгийн тайлан</b>			
Хүүгийн орлого	69.97	4,109.23	<b>5773%</b>
Хүүгийн зардал	8.56	963.16	<b>11146%</b>
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b>61.41</b>	<b>3,146.07</b>	<b>5023%</b>
Хүүгийн бус орлого	9.71	229.49	<b>2264%</b>
Хүүгийн бус зардал	44.54	1,390.35	<b>3021%</b>
Эрсдэлийн сангийн зардал	0.00	124.27	<b>100%</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг</b>	<b>26.57</b>	<b>1,860.94</b>	<b>6904%</b>
Ү/А-ны бус орлого	0		
Ү/А-ны бус зардал	3.50	47.49	<b>1258%</b>
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>23.08</b>	<b>1,813.46</b>	<b>7759%</b>
Орлогын татварын зардал	0.27	184.09	<b>69128%</b>
<b>Цэвэр ашиг</b>	<b>22.81</b>	<b>1,629.37</b>	<b>7043%</b>

2022 оны жилийн эцсийн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хөрөнгө 12.5 дахин, Зээлийн багц 11.5 дахин тус тус өссөн. Зээлийн багцын чанар 98.1% байна.

Нийт 35.6 тэрбум төгрөгийн зээлийн олголт хийж, 15.4 тэрбум төгрөгийн зээл төлөгдөж, зээлийн багц 22.1 тэрбум төгрөгт хүрсэн. Чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 1.9% байгаа нь системийн дунджаас 4.5 дахин бага үзүүлэлт юм.

Дээрх үзүүлэлтүүдийн үр дүнд 2022 онд татварын дараах цэвэр ашиг 1,629.37 сая төгрөгт хүрсний зэрэгцээ Санхүүгийн зохицуулах хорооноос тавьдаг зохистой харьцааны бүх шалгууруудыг ханган ажиллалаа.



Д/д	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР	ХАНГАСАН ЭСЭХ
<b>А. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ</b>				
1	НЭГ ДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	10%-аас доошгүй	38.3%	Хангасан
2	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	20%-аас доошгүй	38.3%	Хангасан
3	НЭГ ДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	10%-аас доошгүй	35.7%	Хангасан
<b>Б. ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА</b>				
4	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА	8%-аас дээш	16.2%	Хангасан
<b>В. АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>				
5	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+илүү,- дутуу )	124,273.8	124,273.8	(0.0)
6	НЭГ ЗЭЭЛДЭГЧ БОЛОН ХОЛБОГ ДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	11.1%	Хангасан
14	ББСБ-ААС ГАРГАСАН ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	70%-аас хэтрэхгүй	0.0%	-
8	ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЖИЛТАН ХОЛБОГ ДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ НИЙЛБЭР ДҮНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	25%-аас хэтрэхгүй	17.6%	Хангасан
7	ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЖИЛТАН, ХОЛБОГ ДОХ НЭГ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	9.9%	Хангасан
9	ҮНЭТ ЦААСНЫ ЭЗЭМШИЛ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	50%-аас хэтрэхгүй	0.0%	-
10	КОМПАНИЙН ХУВЬЦАА, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	0.0%	-
11	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН "Г", "П" АНГИЛАЛЫН НЭГ КОМПАНИЙН ГАРГАСАН ХУВЬЦААНААС ХУДАЛДАЖ АВАХ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	0.0%	-
12	КОМПАНИЙН ӨРИЙН БИЧИГ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	0.0%	-
13	БУСАД ҮНЭТ ЦААС, ҮНЭТ ЦААСНЫ ЭЗЭМШИЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	#DIV/0!	#DIV/0!
<b>Г. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛ</b>				
15	ГАДААД АКТИВ, ПАССИВЫН ЗӨРҮҮ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	(+/-40%)	0.0%	Хангасан
<b>Д. БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>				
16	ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	80%-аас хэтрэхгүй	79.1%	Хангасан
18	ӨРИЙН БИЧГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	50%-аас хэтрэхгүй	24.3%	Хангасан
<b>Е. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>				
17	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	15%-аас хэтрэхгүй	0.6%	Хангасан
<b>Ж. ӨГӨӨЖ</b>				
19	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ӨГӨӨЖ			11.9%
20	ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ			31.0%

**“БУЛЛ КАПИТАЛ ББСБ” ХХК**  
**2023.03.03**